



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/27

Улиастай

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 221 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Завхан аймаг байгуулагдсаны 100 жилийн ойг угтан бүтээгдсэн Отгонтэнгэрийн байгалийн гэрэл зургийг аймгийн Засаг даргын Тамгын газарт байршуулах зардалд зориулж 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Мягмарсүрэн)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Чадраабал)-т даалгасугай.

ДАРГА  Г.ОНОРБАЯР



Захирамж-2023

8109010115